

САЙХАН ХОРШОО НАЙРУУЛГЫГ ЗОХИЦУУЛДАГ...

(Ц.Дамдинсүрэнгийн зохиолууд дахь зарим хоршоо үгийн
хэрэглээнд хийсэн ажиглалт)

Б.Пүрэв-Очир*

Бид 2008 онд хэвлүүлсэн “*Сайн үйлсийг бүтээж, салаа замаар явсан эрдэмтэн-зохиолч*” (Уб., 2008) гэдэг номдоо “*Сайхан хоршоо найруулгын чимэг*” хэмээх бяцхан судалбарыг оруулж, их зохиолчийн найруулгын онцлог, зарим нэг хоршоогийн үүсэл гарваль, үг давтах, авиа сэлгэх, хоршин зэрэгцэх ёсны өвөрмөц зохицол, өнгө аясын талаар цухасхан зүйлийг хөндөж билээ. Эрдэмтэн-зохиолч Ц.Дамдинсүрэнгийн туурвих арга ухаан, үгээр урлах эрдэм, монгол хэлний үг ба утгын сангийн хэрэглээний талыг анхааралтай ажиглавал, монгол хэлний дүрслэх ба дууриах үгс, авиа сэлгэж утга салаалсан үгс, давтан хоршсон үг, хэлц үгс, оноосон ба тусгай нэр, хоч нэр зэргийг зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг илэрхийлэх хэрэглүүр болгон гайхалтай сайхан, чадварлаг хэрэглэсэн нь заххаас аван харагддаг, юм бичиж оролддог хэн болгонд бол сайн туршлага болмоор санагддаг. Үүнийг наад захын нэг жишээ буюу “*Пионерийн лагерь*” (1932) гэдэг хуучин шүлэгт буй:

...Борооны дусал шивэр шивэр ороод,
Булгийн усан пор пор ундраад,
Хойт руу хор хор хоржигноод,
Хос салаа усан мөчир болоод,
Булт хүүхдүүд год шод гүйлдээд
Булчин мах нь эрчлэн мушгиран чангараад,
Олон хүүхэд ярс ярс жагсаад,
Улаан бүч эрвэс дэрвэс хийсээд,
Ийм л сайхан
Тийм л сонихон.
Сэрүүн салхи сэр сэр үлээгээд,
Сэтгэл зүрх луг луг хөдлөөд,
Улбар туг намирс намирс мандаад,
Улаан судал нэвт шувт лугшаад,
.....
Болжмор шувуу гангар гунгар жиргээд,
Бутын ногоо арзайн бурзайн ургаад,

* МУБИС-ийн Монгол судлалын сургууль.

Хуур хөгжим хангир жингэр сонстоод,
 Хушийн мөчир нэлбэс дэлбэс ганхаад,
 Хүсэл зориг давшин дэвшин оргилоод,
 Хүүхэд багачууд инээдэс наадас бололцоод,
 Самар жимс багсайн сагсайн ургаад,
 Сайхан бүгдээр нөхөрлөн журамлан инээлдээд...

гэсэн хэсгээр төлөөлүүлэн харж болохоор байдаг. Энд эш татсан шүлгийн хэсгийн найруулгын зохицол, толгой ба сүүл холбоц, зэргэд үүсгэсэн барилдлага, үг ба утгын шүтэлцээ зэргийг ажваас, *шивэр шивэр, пор пор, хор хор, ярс ярс, сэр сэр, дуг дуг, намирс намирс, давшин давшин* г.м. дууриах ба дүрслэх үгсийн давтан хоршоог; *год шод, эрвэс дэрвэс, нэвт шувт, гангар гунгар, арзайн барзайн, хангир жингэр, нэлбэс дэлбэс, багсайн сагсайн* г.м. авианы сэлгэцээр үүссэн хоршоог; *инээдэс наадас, нөхөрлөх журамлах* г.м. үгийн сангийн ойролцоо утгат хоршоог; *булт хүүхэд, олон хүүхэд, улаан бүч, улбар туг, улаан судал* г.м. эх сэдвийн ойролцоо утгат нэгжийг үлэмж оновчтой өрж, дэс дараатай хэрэглэж, зохиогч сэтгэлийн өнгө аяс, үнэлэмжээ илэрхийлэх хэрэглүүр болгосон нь давтагдашгүй төдийгүй, найруулгын талаасаа өнөөгийнхөнд нэгэн сайн үлигэр загвар болмоор байдаг. Бас нөгөө талаар, өгүүлбэрийн эрхэн ба хүлээн үйлдэгч-үйлийн эзний харьцааг илэрхийлсэн гишүүлбэрийн байрлал, өргөлт, утгын ба хэлбэрийн холбоосжилт нь уран санааг илэрхийлж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг гаргахад чухал үүрэг гүйцэтгэдгийг энэ шүлгийн эн зэрэгцүүлсэн “хоршоо өгүүлбэрүүд” гэж ч нэрлэж болмоор зэргэд бүтцээс үзэж болмоор байдаг юм.

Тухайлбал,

- (S₁) – Борооны дусал ... ороод - (P₁)
- (S₂) – Булгийн усан ... ундраад - (P₂)
- (S₃) – Усан ... хоржигноод - (P₃)
- (S₄) – Хүүхдүүд ... гүйлдээд - (P₄)
- (S₅) – Булчин нь ... чангараад - (P₅)
- (S₆) – Хүүхдүүд жагсаад - (P₆)
- (S₇) – Бүч ... хийсээд - (P₇)
- (S₈) – Салхи ... үлээгээд - (P₈)
- (S₉) – Сэтгэл зүрх ... хөдлөөд - (P₉)
- (S₁₀) – Туг ... мандаад - (P₁₀)
- (S₁₁) – Судал ... лугшаад - (P₁₁)
- (S₁₂) – Болжмор шувуу ... жиргээд - (P₁₂)
- (S₁₃) – Бутын ногоо ... ургаад - (P₁₃)
- (S₁₄) – Хуур хөгжим ... сонстоод - (P₁₄)
- (S₁₅) – Хушийн мөчир ... ганхаад - (P₁₅)
- (S₁₆) – Хүсэл зориг ... оргилоод - (P₁₆)
- (S₁₇) – Хүүхэд багачууд ... наадаад - (P₁₇)
- (S₁₈) – Самар жимс ... ургаад - (P₁₈)
- (S₁₉) – Бүгдээр ... инээлдээд - (P₁₉)

(S_n) - (P_n) г.м.-ээр (энд уламжлалыг бодолцож, энгийн өгүүлбэрийн субъектийг “S” гэж, предикатыг “P” гэж тэмдэглэв) зэрэгцсэн харьцаатай, хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэрүүдийг “*хоршиж байгаа юм шиг*” тийм зохицлоор хэлхсэн нь найруулгын бас л нэг өвөрмөц ур маяг болсон ба ийм тохиолдолд үйлийн холбох “-аад” нөхцөлийг сүүл холбоц дээр хичнээн ч удаа давтаж хэрэглэхэд

эх бичвэрийн найруулга суларч, өгүүлбэрүүд сондгойрдоггүй нь харагдаж буй юм. Энэ бол ардын уранзохиолч Ц.Дамдинсүрэн нь, утгын ба хэлбэрийн холбоос гагнаасыг чадварлаг сайхан тохируулдаг байсныг харуулж байна. Ийнхүү үйл хэлхэцээр зэргэд маягийн “хоршоо өгүүлбэр”-ийг бүтээж холбохоос гадна оноосон нэрээр, тэр дундаа хүний нэр, хоёрдугаар нэр буюу хоч нэр, газар усны нэрийг ашиглан, үгийн наадам буюу каламбур маяг үүсгэн өрж, нэр хэлхэцийн “хоршоо зэргэд” үүсгэсэн нь Ц.Дамдинсүрэн гуайн “Толь Гэндэн” (1933), “Матадын ерөөл” (1974) зэрэг шүлэг зохиолын найруулгад маш өвөрмөц онцлогтой байдаг. Үүнд:

...Манлай тэр газрын нэрээс
Магтаж, заримы нь дурсмаар байна.
Манарсан их Матадын нуруу
Мэнэрсэн их Мэнэнгийн тал

.....
Хангай Шуувалдай, Хажуу цорохан
Буянт өндөр, Бухын дошоот
Булан цайдам, Буутайн шил
Бударгана овоот, Буурын худаг
Ашгийн овоот, Адгийн бүрд
Таван толгой, Тасархай бүрд
Лам чулуу, Ловхын хөөвөр
Цагаан чулуут, Хөх билүүт
Царилын хажуу, Үнээтийн дөрөлж
Өвс ихтэй Өрвөл бүрд
Өвөлжөө сайтай Өгөөмөрийн хөндий
Өлтэй шимтэй Жаран тогоо...
Өлгийд нь төрсөн бидний нутаг

Өм ганзага өөдлөх болтугай! гэсэн сонин баримт байна. Ардын уран зохиолчоос шүлэглэсэн зохиолд газар усны нэрийг ийнхүү эн зэрэгцүүлэн өрж, хоршсон энэ ур маяг нь ардын уран зохиолч Дэндэвийн Пүрэвдоржийн “Сэгс цагаан богд” (1969) найраглалд байдаг:

...Ай даа сайхан говь минь,
Алтан шаргал говь минь,
Анагай гурван цоохор
Ажсин гурван ширдэг
Ах дүү гурван хаалга
Аман гурван сээр
Ар гурван дэл
Алаг гурван шанд
Задгай гурван хээр
Зах гурван бамбуу
Нэр нь хүртэл шүлэг

Нээрээ сайхан нутаг... гэдэг хэсгийг санагдуулам болсон байдаг.

Ер, Ц.Дамдинсүрэн гуайн шүлэглэсэн болон үргэлжилсэн үгийн зохиолуудад “...өөхтэй махыг үм цүм хазна, сүүтэй цайг сүр сар оочилно...” (“Нударган”); “...ашиг хонжсоо, авгай хүүхэн...”, “...гэнгэнэн гунганан суух...”, “...улбайн балбайн хэвтэх...”, “...сав шимийн номд санаа зориг шулуудаж...” (“Буурал ээж”); “...Жаана уулыг

өвөрлөж, Жаахан уулыг арлаж, Хүүнэ уулыг өвөрлөж, Хүйтэн уулыг арлаж..., "...ам самандаа амар сайхан жаргах..." ("Толь Гэндэн"); "...өм ганзага..." ("Шинэ жилийн ерөөл"); "...өрмөг данз, будаг өрмөг..." ("Цоорхой өрмөг"); "...арвайх хад, сэрвийх мод..." ("Нутгаа мөрөөднө"); "...мэх гох..." ("Хув зусаг"); "...нялцгай мялцгай..." ("Хэлдэг гурав, хийдэг гани"); "...хонгинох жингэнэх..." ("Чомгор"); "...давс хужир хольцоотой..." ("Чемодантай юм"); "...ууц нуруу бадайрах...", "...хамуу маагуу...", "...түүний цээжийг цохиход түн түн хийж, гэдсийг нь цохиход шал шал хийж дуугардаг..." ("Хоцрогдсон эмгэнийг сурвалжилсан тэмдэглэл"); "...махир тахир үсэгтэй гэрчилгээнүүд..." ("Сайхан хүүхэн") г.м. сонин содон хоршоо үгийг хэрэглэж, зохиолынхоо хэл найруулгыг зохицолтой сайхан болгосон нь харагдаж байна. Хамгийн сонин хоршоо бол нөгөө "Хув зусаг" (1949) гэдэг бяцхан өгүүллэгт нь байгаа "мэх гох" гэдэг хоршоо үг юм. Энд: "...Хашин загал морь маань түймрийн галаас айгаад, хурдан загал морь болчихов. Түүний хашин хойрго зан нь бүр "мэх гох" юмсанжээ. Одоо манай загал морь жолоо залсан тийш хар хурдаараа давхидаг болов..." гэсэн өгүүлбэр байдаг. Адгуусыг хүнчлэн зүйрлэсэн энэ хэсэгт л монгол хэлний "мэх", "гох" гэдэг хоёр үг хоршин зэрэгцэж метафоржсон хоршоо үүсгэсэн байна. Энэ нь гагцхүү урансайхны эх үүсгүүртэй эх бичвэр буюу хам хүрээнд, монгол нүүдэлчдийн танин мэдэхүйн уг үндэстэй тодорхой нэг зохиолын бай-хүрээнд байж болдог жамтай юм. Өөрөөр хэлбэл, монгол хэлэнд "цэцэг", "цэврүү" хоёр хорших, "онгө", "мөнгө" хоёр хорших, "мухар", "сохор" хоёр хорших, "гал", "ус" хоёр хорших, "газар", "тэнгэр" хоёр хорших, "баян ноён", "сул тайж" хоёр хорших, "хаан", "харц" хоёр хорших, "нүд", "чих" хоёр хорших "нүгэл", "буян" хоёр хорших, "мэх", "гох" хоёр хорших нь зөвхөн тухайн эх сэдэвт л байж болох тодорхой хам-хүрээтэй, бас өвөрмөц нэгэн бай-хүрээтэй метафоржсон хоршоогийн дүрс юм. Жишээлбэл, "Би баян ноёны хүү ноёнд захирагдахаас, зүгээр нэг сул тайжид захирагдахгүй гэж байсаар удалгүй тааллаа хураасан гэлцэнэ. Ийм л маягаар номтой номгүй, ноёд албат, лам хар, баян барлагийн хооронд зөрчил тэмцэл болсон зах газрын бага буурай хошуу Асаатын голын бачим цухал жалгад Жамъянгаравын ном эрдмийн гэгээ нэмсээр байжээ" (Сүрэнхорын Жамъянгарав: "Цаглахуй санааны найлзуур мод", Зохист аялгууны жишээ шүлгүүд, 2011 номоос) гэсэн өгүүлбэрээс эх сэдвийн хоршоог эсрэг ба ойролцоогоор нь хэрхэн зөв зохистой үүсгэж хэрэглэснийг харж ажиглаж болохоор байна. Энэ мэтээс үүтгэн бодвоос, монгол хэлний "мэх", "гох" гэдэг хоёр нэр үг бол утгын ойролцоо оронд байдаг, эх үүсвэрт ойролцоо дүр зураг илэрхийлдэг гэсэн үг юм. Монгол бөхийн олон зуун мэхэн дотор "дэгээ", "дэгээ ороох", "дэгээдэх", "дотуур дэгээ", "гадуур дэгээ", "дэгээ эргүүлэх" г.м. өлгөж гогодох арга "мэх" байдаг. Гэтэл бас алив буу шийдмийн, замаг түгжээний, хаалга хамарны, заль мэхний "гох" бол огцом эргэсэн мэхгэр мэтгэр, гох дэгээ хэлбэртэй, орон зай, цаг хугацааны хувьд эргэлт түргэнтэй зүйл байдаг. Тэгэхлээр монгол хэлний "мэх" бол "гох" юм, "гох" бол "мэх" юм гэж хэлэх үндэстэй бөгөөд "гох", "мэх" хоёул нэгэн зүйл арга хэрэгсэл болох буюу "гох"-оос "мэх"-рүү утга шилжих, "мэх"-ээс "гох"-руу утга шилжиж метафор үүсгэдэг тийм нэгэн утгазүйн зүй тогтол байдаг гэсэн үг юм. Ерөөсөө "эх сэдвийн ойролцоо ба эсрэг нэр" ингэж л үүсдэг зүй тогтолтой юм. Тэгэхлээр Ц.Дамдинсүрэн гуай "мэх", "гох" хоёр хоршиж хэрэглэгдэж болохыг ертөнцийн дүр зургаас мэдсэн тийм туршлага, хэл-сэтгэхүйн холбооны тийм тусгал байсан гэж монгол ухаан-шинжээний талаас хэлж болох юм.

Бас нэгэн зүйл бол, Ц.Дамдинсүрэн гуай нэгэн үед ШУА-ийн Судар бичгийн хүрээлэн, одоогийн Хэл зохиолын хүрээлэнд олон жил хамт ажилласан Я.Цэвэл гуайн зохион найруулж байсан *“Монгол хэлний товч тайлбар толь”*-д *“гох мэх”*, *“мэх заль”* гэсэн хоёр хоршоо үг орж тэмдэглэгдсэнийг толийн ноорог навтаргаас олж үзсэн, гярхай ажигласан ба хожмоо зохиол бүтээлдээ авч хэрэглэсэн байж болох. Эс бөгөөс тольч эрдэмтэн Я.Цэвэл, толь бичгийнхээ толгой үгийн санг бүрдүүлж, үг хэллэг, жишээ тайлбар сэлтийг утгазохиолын хэлнээс базааж зэхэж байхдаа Ц.Дамдинсүрэнгийн *“Хув зусаг”*-ийг уншаад, тэрхүү утгын сайхан зохицолтой *“мэх гох”* гэдэг хоршоог олж авч, *“гох”* гэдэг үгийн тайлбарыг хийхдээ авч ашигласан байж болох тийм хоёр тал анзаарагдаж байгаа билээ.

Ер нь ажиглаад байхад, үгийн сан–эх сэдвийн бие даасан тогтвортой нэгж болж, элдэв толь бичигт суусан хоршоо үг тун цөөн байдгийн нэг нь бидний сонирхоод байгаа *“гох мэх”* гэдэг хоршоо юм. Урансайхны эхэд тодорхой бай-хүрээнд хэрэглэгдсэн метафоржсон хоршоо бол дүр дүрслэлийг нүдэнд үзэгдэхүйц дүрслэг болгож, мэдээллийг чихнээ сонсголонт болгож, санаа ойлголтыг ой тойнд ортол хялбаршуулахад чухал үүрэгтэй, зохиолын хэл найруулгыг үлэмж сайхан эмх цэгц, зохицолтой болгодог хэрэглүүр гэдгийг Монгол улсын анхны ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн зохиол бүтээлийн хоршоо үгийн зохицол, туурвилзүйн жишээ туршлага бэлхнээ харуулж байна л даа.

Энд бид *“авьяас”*, *“арга”*, *“туришлага”*, *“сайхныг мэдрэх”*, *“билгийн нүд”*, *“уран чадвар”*, *“найруулах эрдэм увдис”*, *“хоршоогийн зохицол”* ... г.м. хэдэн үгийг онцолж байна. Манай Монгол улсаас төрөн гарч, яндашгүй их үнэт зүйлийг бүтээсэн бичгийн хүмүүс–ардын уран зохиолчид л гэхэд Цэндийн Дамдинсүрэн, Сэнгийн Эрдэнэ, Сормууниршийн Дашдооров, Дэндэвийн Пүрэвдорж, Шаравын Сүрэнжав, Бавуугийн Лхагвасүрэн, Пунцагийн Бадарч, Тангадын Галсан, Лодонгийн Түдэв, Бөхийн Бааст, Дөнгөтийн Цоодол... тэргүүтэн нь *“найруулгазүй”*, *“үгзүй”*, *“өгүүлбэрзүй”*, *“үг хорших ёс”* г.м. хэлшинжлэлийн ухаануудыг нэг их заалгаж, онол – түүхийг нь овойж оцойтол үзэж судалж явсан гэвэл үнэнд хэр зэрэг нийцэх бол?! Гагцхүү *“их бичсэн туришлага”*, *“өөрөөсөө өөрийгөө олж нээсэн, таньсан монгол ухаан”*, *“нөр их оролдлого хөдөлмөр”*, *“сайхныг мэдрэх”*, *“билгийн нүд”* л энэ авьяас билигт зохиолчдыг *“сайн найруулга”*-д сургаж л дээ! Найруулах эрдмийг үйлийн явцад сурдаг бололтой.

Зохиолч ч бай, сэтгүүлч ч бай, эрдэмтэн ч бай, эмч ч бай хоршоо үгийг олж сонгосоор, хэрэглэн хэрэглэсээр, хоршоо гуршаа үгсийн найруулгын үүрэг холбогдол, сайхан хоршоо- найруулгын чимэг, сайн хоршоо найруулгыг зохицуулдаг гэдгийг ойлгож, мэдэрдэг улмаар хэрэглэж сурдаг жамтай аж.

“Далайн хөвөөнд суудаг айлын хүүхэд багачуул хэний ч шахалт шаардлага, сургаал зааваргүйгээр хар нялхаасаа усанд сэлээд сурчихсан байдагтай адил” далай баян монгол хэлнийхээ үг, утгын сангаас үг, өгүүлбэрийг нь тунгааж, хоршин хоршин хэрэглэсээр, сайн бичиж, зөв сайхан хэлж ярьсаар эх хэлнийхээ хоршоо үгийн найруулгын учир начрыг ойлгож, чадварлаг зөв хэрэглэж сурахын нууц нь энд л байгаа юм даа.

SUMMARY

In this article, the author investigated the use of Mongolian compound words and how the phenomenon of the universe could be expressed distinctly and precisely by compound words. Compound words play important role to the stylistics to make sentences ideal that exemplified by the works of Ts.Damdinsuren.

НОМЗҮЙ

Б.Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, дөтгөөр дэвтэр, үгүүлбэрийн зүй, Уб., 1967

Б.Пүрэв-Очир, *Сайн үйлсийг бүтээж, салаа замаар явсан эрдэмтэн-зохиолч, МУ-ын ардын уранзохиолч Цэндийн Дамдинсүрэнгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулав*, Уб., 2008 он

Б.Пүрэв-Очир, А.Цог-Очир, *Монгол хэлний хорших ёсны хэв шинж, бүрэлдүүлбэрийн талаар хийсэн зарим ажиглалт*, Mongolian studies: ¹ 12, 2002, The Korean Association for Mongol Studies.

Сүрэнхор Жамъянгарва, *“Цаглахуй санааны найлзуур мод”* (Зохист аялгууны жишээний шүлгүүд), Уб., 2011

Дарма Батбаяр, *Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц*, Уб., 2007

Ж.Бат-Ирээдүй, *Монгол хэлний хоршоо болон давтмал үг хэллэгийн сан*, “zöv zam” books, 2009.